Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Зөрчлийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Энэбиш Бямбацэцэг

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн , дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх | | | | | | | |
| 1 | Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагууд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин | - | - | -Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 03-00/12 дугаартай удирдамжийн хүрээнд Шинжлэх ухааны академийн Физик технологийн хүрээлэнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж ажилласан. Шалгалтаар тус байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байх тул улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Ерөнхий дүнгээр тус | 3-р сар, 5-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 80%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага нь 17.8 хувь буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн болно. - Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5*3.1 дэх хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний хүрээнд ХААИС-ийн харьяа Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 03-00/14 дугаар бүхий удирдамжийг боловсруулж, батлуулсан. Тус шалгалтыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 08 дугаар сарын 23-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ч Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/50 тушаалаар байгуулсан дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа 3, 4, 5 дугаар сард үргэлжлэн хийгдсэн тул тус шалгалтыг 08 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр хойшлуулсан. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтийн улмаас яамны эрхлэх асуудалд өөрчлөлт орж, тус хяналт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгалтыг хийх боломжгүй болсон. Хавсралт: 2 файл | | |
| 2 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 95% | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 100% Зөрчил арилгуулалтын хувь - 90% | -Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/50 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэлт гаргах зорилгоор ажлын хэсгийн хамт Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль, Олон улсын эдийн засаг бизнесийн их сургууль, ИЗОУИС-ийн харьяа Дүрслэх урлаг, дизайн технологийн дээд сургууль, Энэрэл дээд сургууль, Орхон дээд сургууль, Хангай дээд сургууль, Санхүү бизнесийн дээд сургууль, Мон Алтиус дээд сургууль, Оточ манрамба дээд сургууль, Үндэсний батлан хамгаалах их сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Налайх дахь МГТИС, Отгонтэнгэр их сургууль, Их Засаг Олон улсын их сургууль, Рояаль их сургууль, Улаанбаатар эрдэм их сургууль, ОУ-ын Улаанбаатарын их сургууль, Этүгэн их сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Эрдмийн их сургууль, Аварга дээд сургууль, Технологийн дээд сургууль, Хөдөлмөр нийгмийн харилцааны дээд сургууль, Шинэ Монгол дээд сургууль зэрэг нэр бүхий 35 сургуульд хяналт шалгалт хийж ажилласан. -Салбарын хяналтын | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын даргын баталсан 03-00/26 дугаар удирдамжийн дагуу Нийслэлийн боловсролын газрын улсын /ахлах/ байцаагчдын албан бичиг, өргөдөл гомдол барагдуулалт, улсын /ахлах/ байцаагчийн үйлдсэн эрх зүйн баримт бичгүүд, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын дүнг 2024 оны 06 сарын 17-ны өдөр Салбарын хяналтын газрын шинжээч Д.Өнөржаргал, ахлах мэргэжилтэн Д.Батсүх нарын хамт очиж танилцуулсан. -2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Боловсролын сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Мэдлэг боловсролын парк” сургалтын төвийн үйл ажиллагаа, суралцагчийн бүртгэл, суралцагчид олгож байгаа боловсролын баримт бичигт хяналт, шалгалт хийсэн. -Боловсролын сайдын 2024.12.02-ны өдрийн А216 дугаар тушаалын дагуу удирдамжид дурдсан Ерөнхий боловсролын 12 сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж байна. Нийт 49.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.2. Зөрчлийн хэрэг бүртгэлтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, удирдлага, арга зүйгээр ханган ажиллах | | | | | | | |
| 3 | Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаанд | Зөрчлийн тоо Торгууль шийтгэврийн | Зөрчлийн тоо - 130 Торгууль шийтгэврийн | Зөрчлийн тоо - Тухай бүр Торгууль | -Аймаг, Нийслэлийн боловсролын газрын эрх бүхий албан тушаалтнуудаас илрүүлсэн зөрчил, | 3-р сар, 4-р сар, 5-р сар, | Өөрийн үнэлгээ: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангах | барагдуулалтын хувь | барагдуулалтын хувь - 89,8% | шийтгэврийн барагдуулалтын хувь - 90% | түүнд авсан арга хэмжээний судалгааг улирал тутамд авч, хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт 116 зөрчлийг /12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар/ прокурорын байгууллагад бүртгүүлэн, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан ба торгууль шийтгэврийн дүн 24.1 сая төгрөг, барагдуулалт 92 хувь. Мөн тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсны орлого 33700.0 мян төгрөгийг улсын орлого болгохоор болсон. -УЕП, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал", "Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам", Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх гэж байгаатай холбогдуулан УЕП, НПГ-аас ирүүлсэн мэдээллийг салбарын нийт улсын байцаагчдад цахим групп болон албан тоотоор хүргүүлж, удирдлага арга зүйгээр ханган ажилласан. Энэ хүрээнд аймгуудын Боловсролын газрын дарга, улсын /ахлах/ байцаагч нарт “Аргачлал журмын хэрэгжилт хангуулах тухай” 13/1523 дугаартай албан тоотыг боловсруулж хүргүүлсэн. -Баян-Өлгий, Сүхбаатар, Төв, Увс, Булган, Завхан, Дорноговь, Говь-Алтай зэрэг | 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 100%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аймгийн улсын байцаагч нарт Зөрчлийн хэргийн бүрдүүлбэр, улсын байцаагчийн эрх хүсэх материалын бүрдлүүд, зөрчлийн хэрэг үүсгэх, прокурорын байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлын талаар мэдээлэл өгч, арга зүйгээр ханган ажилласан. - Нийслэлийн прокурорын газарт Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан үндэслэлээр шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг, гомдлын талаарх судалгаа болон энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний товч танилцуулга болон судалгаа, мэдээллийг 4 удаа хүргүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4 | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх | Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь | Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо-5 Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь-100 | Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо-Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь-90% | Тайлант хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Салбарын хяналтын газраас Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 03-00/16 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх явцад гадаадын хөрөнгө оруулалттай "Найтын Австрали-Монгол" ЕБС нь боловсролын стандарт /ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS6782:2019/, сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг зөрчсөн, Улсын комисс хүлээж аваагүй байгууламжид үйл ажиллагаа явуулсан гэх, Иргэнээс | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирүүлсэн гомдлын хүрээнд Салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 03-00/22 дугаартай удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийслэлийн ерөнхий боловсролын 6 дугаар сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх явцад Боловсролын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх хэсгийг зөрчсөн гэх, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 1111 төвөөр дамжуулан "Хүмүүн цогцолбор цэцэрлэгийн эрхлэгч болон бүлгийн багш нар хүүхдийн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих эрхийг зөрчиж байгаа гэх, Нийслэлийн Ерөнхий боловсролын "Өнөр" сургуулийн удирдлагын хууль бус шийдвэр, сургуулийн барилга байгууламж, санхүүгийн үйл ажиллагааг шалгуулах гэх, Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоны хилийн цэргийн албан хаагчдын эцэг эхийн төлөөллийн тус тосгон дахь ЕБС болон цэцэрлэгийн үйл ажиллагаа Монгол сурагчдын эрх ашгийг зөрчдөг, өдөр тутмын бүх хэрэглээ казах хэл дээр явагддаг гэх, "Япон Кеа бизнес нийгэмлэг" төв нь ГБХНХЯ-ны зөвшөөрөлгүйгээр ЕБС-ийн сурагчдад сургалтын үйл ажиллагаа явуулж байна гэх гомдол мэдээллийг хүлээн авч, Боловсролын яамны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналтын | | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүртгэлд бүртгэсэн. Эдгээр гомдол мэдээллийг хуулийн хугацаанд прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт 116 зөрчлийг /12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар/ прокурорын байгууллагад бүртгүүлэн, хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлэсэн. Хавсралт: 1 файл | | |
| 5 | Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны хэрэглээнд хяналт тавих | Шийтгэлийн хуудасны тоо Торгууль шийтгэврийн барагдуулалт | Шийтгэлийн хуудасны тоо-Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалт-80% | Шийтгэлийн хуудасны тоо-Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалт-90% | Тайлант хугацаанд Салбарын хяналтын газар, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Нийслэлийн боловсролын газрын улсын /ахлах/ байцаагчдад Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл оногдуулах шийтгэлийн хуудас буюу маягт 2, Шийтгэлээс чөлөөлөх хуудас буюу маягт 5-аас нийт 43 ширхэгийг шаардах хуудсаар олгож, бүртгэлжүүлсэн. Эрх бүхий албан тушаалтнуудын шийтгэлийн хуудсаар оногдуулсан торгууль шийтгэврийн барагдуулалт 100 хувь байна. | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 6 | Эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, ЭБАТ-ны өөрчлөлтийн | Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо Хүргүүлсэн судалгаа, | Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо-21 Хүргүүлсэн | Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо-Тухай бүр Хүргүүлсэн | -УЕП, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаалаар "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал", "Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг прокурорын байгууллагад хүргүүлэх | мэдээллийн тоо | судалгаа, мэдээллийн тоо - 4 | судалгаа, мэдээллийн тоо -Тухай бүр | байгууллага хооронд мэдээлэл солилцох журам"-ыг баталсан, Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг 05 сарын 01-ээс хэрэглээнд нэвтрүүлж байгаатай холбогдуулан УЕП, НПГ-аас ирүүлсэн мэдээллийг салбарын нийт улсын байцаагчдад цахим групп болон албан тоотоор хүргүүлж, удирдлага арга зүйгээр ханган ажилласан. -Аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, улсын /ахлах/ байцаагч нарт “Аргачлал журмын хэрэгжилт хангуулах тухай” 13/1523 дугаартай албан тоотыг боловсруулж хүргүүлсэн. -Салбарын улсын ерөнхий байцаагчийн 13/1523 дугаартай албан бичгийн хүрээнд аймгуудын БШУГ-ын дарга, улсын /ахлах/ байцаагчдаас ирүүлсэн төлөвлөгөөг нэгтгэн, санал боловсруулсан. -Говь-Алтай аймгийн БГ-ын улсын байцаагч Ц.Түмэнжаргалд "Цэцэрлэгийн багш хүүхэд зодсон" асуудлын тухайд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тухайн гомдлыг аймгийн Цагдаагийн байгууллагад шилжүүлүүлсэн. -Нийслэлийн прокурорын газраас ирүүлсэн албан тоотын дагуу 2024.02.27-ны өдөр зохион байгуулсан "Удирдлагын манлайллыг дээшлүүлж, хууль хэрэглээг сайжруулах нь" сэдэвт хамтарсан зөвлөгөөний тухай мэдээллийг холбогдох албан хаагчдад хүргэж, оролцоог хангуулах ажлыг зохион байгуулсан. | сар, 11-р сар | үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Баян-Өлгий, Завхан, Төв, Сүхбаатар, Увс, Булган аймгийн улсын /ахлах/ байцаагчдад зөрчлийн хэрэг бүртгэл, торгох шийтгэл, эрх зүйн хэлбэрүүдийг зохистой ашиглах талаар зөвлөгөө өгч ажилласан. -Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, яамны нэр, эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан албан хаагчдын имэйл хаяг өөрчлөгдсөн, улсын ахлах байцаагч А.Мөнхзаяа хүүхэд асрах чөлөө нь дуусгавар болж ажилдаа орсон, түр орон тоон дээр ажиллаж байсан Г.Сүнжидмааг чөлөөлж өөр ажилд шилжүүлсэн зэрэг өөрчлөлтийг тусган ЭБАТ-ны шинэчилсэн болон бусад 5 төрлийн судалгаа, мэдээлэл, танилцуулгыг НПГ-т хүргүүлсэн.<br>Хавсралт: 5 файл | | |
| 7 | Боловсролын салбарын зөрчлийн хэрэг бүртгэлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Бүртгэгдсэн зөрчлийн хэргийн тоо Торгууль шийтгэврийн дүн, барагдуулалт | - | Бүртгэгдсэн зөрчлийн хэргийн тоо-Тухай бүр Торгууль шийтгэврийн дүн, барагдуулалт-Тухай бүр | -Аймаг, Нийслэлийн боловсролын газрын эрх бүхий албан тушаалтнуудаас илрүүлсэн зөрчил, түүнд авсан арга хэмжээний судалгааг улирал тутамд авч нэгтгэн мэдээллийн сан үүсгэж байна. Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт 116 зөрчлийг /12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар/ прокурорын байгууллагад бүртгүүлэн, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Торгууль шийтгэврийн дүн 24.1 сая төгрөг. Барагдуулалт 92 хувьтай байна. Мөн тусгай зөвшөөрөлгүй үйл | 6-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаа явуулсны орлого 33700.0 мян төгрөгийг улсын орлого болгохоор болсон. -<br>Хавсралт: 3 файл | | 100% |
| 8 | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан сургалт зохион байгуулах. | Сургалтын тоо | Сургалтын тоо-1 | - | -Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1.3, 9.1.4 дэх заалт, Салбарын хяналтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Аймаг, Нийслэлийн Боловсролын газрын хяналтын улсын /ахлах/ байцаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А/42, А/71, А/43, А/72 тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал", "Эрх хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журам"-ын хэрэгжилтийг нэг мөр хангуулах зорилгоор эрх бүхий албан тушаалтнуудын хууль хэрэглээний чадавхийг нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулан 2 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад аймаг, нийслэлийн 34 эрх бүхий албан тушаалтан хамрагдсан.<br>Хавсралт: 4 файл | 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.3. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулах, батлуулах, санал өгөх, хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүйгээр хангах | | | | | | | |
| 9 | Эрх зүйн актыг | Саналын тоо | - | - | -МУ-ын ЗГ-ын тухай хуулийн 24 | 3-р сар, | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах, батлуулах, санал өгөх, хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүйгээр хангах | | | | дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, ТХШТХ-ийн 5*5.3 дахь заалт, ЗГ-ын 2022 оны 479 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 3.4 дэх хэсэг, ЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоолыг үндэслэн "Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай" тушаалын төслийг боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/15 дугаар тушаалыг батлуулсан. -Тушаал болон Салбарын хяналт, ЦЦАБХ-ын чиглэлээр 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг яамны албан ёсны вэб сайтын ил тод хэсэгт байршуулсан. /https://www.meds.gov.mn/post/152456 -НПГ-аас ирүүлсэн 2024 оны Ц-1/2314 дугаартай албан бичгийн дагуу Улсын ерөнхий прокурорын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/55 дугаартай “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” тушаалын хавсралтад Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоож, яамны нэр, эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан гарсан өөрчлөлтийг тусгуулахаар 11/2336 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн. -ЗГХХГ-аас ирүүлсэн 01/752 дугаартай | 4-р сар | үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Мэдээлэл ирүүлэх тухай" албан бичгийн дагуу 2023, 2024 оны хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн бүртгэл зэрэг ирүүлэх мэдээллийн жагсаалтад дурдсан судалгааг шинжээч Д.Өнөржаргалын хамт /улсын хэмжээнд/ гаргаж хүргүүлсэн. -ЗГХХГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу хяналт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замын талаар мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн. -ТХШТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор Хяналт үнэлгээний үндэсний хороо, ЗГХХГ-аас байгуулсан дэд ажлын хэсэгт хяналтын улсын байцаагчийн хяналт тавьж хэрэгжүүлэх хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, тоо зэрэг судалгааг шинжээч Д.Өнөржаргалын хамт гарган хүргүүлсэн.<br>Хавсралт: 1 файл | | |
| 3.3. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах | | | | | | | |
| 10 | Улсын байцаагчийн эрх олгох, цуцлах ажлыг хариуцан зохион байгуулж, үнэмлэх, тэмдгийн | Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ | Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо - 14 Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ - 100% | Эрх олгосон, цуцалсан тушаал шийдвэрийн тоо - Тухай бүр Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ - | -Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, яамны нэр, эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан Боловсролын сайдын "Тушаалд өөрчлөлт оруулах, улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг шинэчлэх тухай" тушаалын төслийг | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглээнд хяналт тавих | | | 100% | боловсруулж, А/56 дугаар тушаалыг батлуулсны дагуу нийт 59 улсын /ахлах/ байцаагчийн албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдгийг солих, бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд хуучин үнэмлэх, тэмдгийг бүртгэлд хамруулан хураан авах, шинээр захиалж хийлгэн бүртгэлд хамруулан олгох ажлыг гүйцэтгэсэн. -Тайлант хугацаанд буюу 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 21 хяналтын улсын байцаагчид хамаарах эрх олгох болон цуцлах тухай 13 тушаалыг боловсруулж батлуулсан. Тухай бүрт нь хяналтын улсын байцаагчийн албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх тэмдгийг захиалах, хэвлүүлэх, албажуулах, бүртгэлжүүлэн олгох ажлыг хийж гүйцэтгэсэн. -Улсын байцаагчийн 03-16-00/035 дугаар бүхий үнэмлэх, тэмдгийг үрэгдүүлсэн тул "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам"-ын 5.1, 5.2-т заасны дагуу уг үнэмлэх, тэмдгийг хүчингүйд тооцох тухай тушаалын төслийг боловсруулж батлуулсан. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 6 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам”-ын 3.5-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/581 дүгээр тушаалыг үндэслэн улсын байцаагчийн 03-16-00/035 | сар, 11-р сар | Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаартай үнэмлэх, тэмдгийг хүчингүйд тооцсон болохыг "Өглөөний сонин" сонины 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн №053 /4066/ дугаарт хэвлэн нийтлүүлсэн.Улмаар Хас тамга үйлдвэрт захиалга өгч, 03-16-00/073 дугаар бүхий тэмдгийг гаргуулан авах ажлыг зохион байгуулсан. -Мөн хяналтын улсын байцаагчдын үйлдэх хяналт шалгалтын баримт бичгийг шинэчлэх ажлыг зохион байгуулсан. -СХГ, НБГ-ын Эрх бүхий албан тушаалтнуудын тамга тэмдгийн дардсын судалгааг 2 удаа авсан.<br>Хавсралт: 3 файл | | |
| 11 | Улсын байцаагчийн үйлдсэн хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгож, хяналт тавих | Олгосон хэвлэмэл хуудасны тоо Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо | Олгосон хэвлэмэл хуудасны тоо - 192 Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - 55 | Олгосон хэвлэмэл хуудасны тоо - Тухай бүр Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - Тухай бүр | Тайлант хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар улсын ахлах байцаагчдад -Хяналт шалгалтын удирдамжийн хэвлэмэл хуудас 53, Хяналт шалгалтын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас 205, Улсын ахлах байцаагчийн албан шаардлагын хэвлэмэл хуудас 79, Хяналт шалгалтын танилцуулгын хэвлэмэл хуудас 23, Улсын ахлах байцаагчийн акт 4, Улсын ахлах байцаагчийн дүгнэлтийн хэвлэмэл хуудас 2, Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийн хэвлэмэл хуудас 10, нийт 376 хэвлэмэл хуудсыг бүртгэлд аван олгосон байна. Мөн тайлант хугацаанд Хяналт шалгалтын удирдамж 39, Албан шаардлага 27, Зөвлөмж 1, Улсын ахлах | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байцаагчийн акт 1, нийт 68 хяналт шалгалтын баримт бичгийг хянаж, нэгдсэн дугаар олгон бүртгэлжүүлсэн. | | |
| 12 | Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх | Хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 100% | Хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийн хувь - 100% | -Сайдын А тушаалын хэрэгжилтийг тайлагнасан. -Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/38 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийнхэн “Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр худалдан авсан тавилга, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний зарцуулалтад хяналт тавьж, тооллого хийх” ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд Ерөнхий боловсролын 157, 142, 44 дүгээр сургууль, 313 дугаар цэцэрлэг, “Бодь электроникс”, “PC молл” компанийн төв агуулах, “Долоон болдог” ХХК-ийн үйлдвэр болон агуулах дээр очиж ажиллан тулган баталгаажуулалт хийн техникийн тодорхойлолтод нийцээгүй, чанарын шаардлага хангаагүй, ашиглаагүй тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний мэдээллийг баримтжуулан цаашид авах арга хэмжээний саналын хамт ажлын хэсгийн ахлагчид илтгэх хуудсаар хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэгч “Чиглэл” компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулан 44 дүгээр сургуулийн гал тогооны ашиглахгүй байгаа болон эвдэрсэн тоног төхөөрөмжийг засварлах, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ашиглалтад оруулах ажлыг хийж гүйцэтгүүлэн, дутагдлыг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авсан. Мөн БЗД-ийн 10 дугаар хороонд байрлах Ерөнхий боловсролын 142 дугаар сургуулийн захиралд Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлагыг ханган ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. -Төрийн нарийн бичгийн даргын А/112 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэгт ажилласан. -СХГ-ын 9 удаагийн хурлын тэмдэглэлийг хөтөлж, албажуулсан. Сайдын шуурхай хурлаас өгсөн 32 үүрэг даалгаврын нэгтгэлийг гаргаж, биелэлтийг системд бүрэн оруулсан эсэхийг нягталж, тулгалт хийн холбогдох газруудаар биелэлтийг системд оруулуулсан. -Улсын /ахлах/ байцаагчдын хууль хэрэглээний мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд 2 байгууллагатай гэрээ байгуулах, хөтөлбөр боловсруулах, тушаалын төсөл боловсруулж батлуулах зэрэг ажлыг гүйцэтгэсэн. -СХГ-ын 7 хоног тутмын ажлын мэдээг нэгтгэн тайлагнаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 13 | Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах | Боловсруулж батлуулсан төлөвлөгөөний тоо | Боловсруулж батлуулсан төлөвлөгөөний тоо-1 | - | Яамны нэр, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсны дагуу Төрийн албан хаагчийн төлөвлөгөөг төрийн мэдээллийн цахим системд шинэчлэн оруулж баталгаажуулсан. | 1-р сар, 2-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 14 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг шийдвэрлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн зохих заавар, журмыг мөрдөх | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн тоо Шийдвэрлэлтийн хувь | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн тоо -29 Шийдвэрлэлтийн хувь-100 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн тоо - Тухай бүр Шийдвэрлэлтийн хувь-100 | Тайлант хугацаанд нийт 25 албан бичиг, 8 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Тухайлбал, “Халмон трейд” ХХК-аас ирүүлсэн 2024.10.29-ний өдрийн албан тоотод дурдсан асуудлыг шийдвэрлэхээр АШУҮИС-ийн Хангамж үйлчилгээний газрын дарга О.Баярсайхантай уулзаж, 1.Зууны мэдээ сонины №160 дугаар /8 нүүр буюу 4 хуудас/ 2.“Халмон трейд” ХХК-ийн авто зогсоолыг түрээслэн ажиллуулах хүсэлт /2024-09-02 №0/98, №0/99/ 3.Зүүн кампус дахь зогсоолын кадастрын болон фото зураг 4.АШУҮИС-ийн Зүүн кампус дахь авто зогсоол ажиллуулах түрээслэгч сонгон шалгаруулах тухай 08 сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэл /2 хуудас/ 5.АШУҮИС-ийн Зүүн кампус дахь авто зогсоол ажиллуулах түрээслэгч сонгон шалгаруулах тухай 10 сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэл /3 хуудас/ 6.Оролцогч талуудаас ирүүлсэн | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүсэлт /5 хуудас/ 7.АШУҮИС-ийн ректорын “Ажлын хэсэг байгуулах тухай” А/189 дүгээр тушаал 8.АШУҮИС-ийн Зүүн кампусын Хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Ц.Батхуяг, “Халмон трейд” ХХК-ийн захирал О.Бямбадэлгэр нарын байгуулсан “Автомашины зогсоолын талбай түрээслэх хамтрах ажиллах гэрээ” нэртэй хүчин төгөлдөр бус гэрээ /10 хуудас/ 9.АШУҮИС-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос ирүүлсэн №24/10-5 дугаартай хүсэлт түүний хавсралт /8 хуудас/ 10.АШУҮИС-аас оролцогч талуудад хүргүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01/665-01/669 дугаартай “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан тоот /5 хуудас/-той тус тус танилцаж, иргэнд хариу өгсөн. -Иргэн Ц.Хишигсүрэнгээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхээр “Эрдмийн өргөө” сургуулийн менежер С.Бямба, Дизайн технологийн Заах аргын нэгдлийн ахлагч Б.Болормаа нараас тайлбар авч, тус сургуулийн Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт, Менежер С.Бямбын уулзалтын тэмдэглэл, сургуулийн захирлын 2023-08-31-ний өдрийн Ц.Хишигсүрэнг ажилд томилох тухай Б/101, 2024-11-08-ны өдрийн Ц.Хишигсүрэнг ажлаас чөлөөлөх тухай Б/159 дүгээр тушаал, Ц.Хишигсүрэнгийн 2024-11-01-ний өдрийн сургуулийн захиргаанд гаргасан “Ажлаас гарахыг хүсэж буй” тухай өргөдөл зэргийг судлан, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэнд хариу хүргүүлсэн. | | |
| 15 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна. | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна. | - | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. | 1-р сар, 2-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 16 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах | Тайлангийн тоо | Тайлангийн тоо-2 | Тайлангийн тоо-1 | -Сарын ажлын тайланг тогтмол тайлагнасан. -Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас болон бүтэн жилээр заасан хугацаанд тайлагнасан. | 6-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 100% |
| 3.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | | | | | | | |
| 17 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | - | - | -Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5*5.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 3.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоолыг үндэслэн "Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай" тушаалын төслий боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/15 дугаар тушаалыг батлуулсан. -Тушаал болон Салбарын хяналт, Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын чиглэлээр 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг яамны албан ёсны вэб сайтын ил тод хэсэгт байршуулсан. /https://www.meds.gov.mn/post/152456<br>Хавсралт: 1 файл | 3-р сар, 4-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах | Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна. | - | - | Төрийн албаны сургуулийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, амжилттай төгсөн сертификат гардсан. | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 2 | Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн баталсан дүрэм журмыг уншиж судлах | Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн баталсан дүрэм журмыг уншиж судлах. | Хууль эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байна. | Хууль эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байна. | -"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагаас зохион байгуулсан Монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох тестийн шалгалтыг өгсөн. - Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлын хүрээнд албан хаагчдад зориулан гаргасан "Монгол бичгийн гарын авлага-1" цахим сурах бичгийг судалж байна. - Салбарын хууль тогтоомж болон Зөрчлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг уншиж, судалж | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | | |
| 3 | Мэдлэг, боловсролоо дээшлүүлэх зорилгоор танхимын болон цахим сургалтад хамрагдах | Яам болон холбогдох бусад газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана. | Танхимын болон цахим сургалтад хамрагдсан байна. | Хамрагдсан сургалтын тоо-Тухай бүр | -Удирдлагын академиас зохион байгуулсан “Манлайлал: Бусдад нөлөөлөх нь” сэдэвт лекцэд хамрагдан, “Смарт Дийл” компанийн үүсгэн байгуулагч Д.Болорын тавьсан илтгэлийг сонсон “Манлайлал яагаад чухал сэдэв болов, Зорилго үнэт зүйл гэж юу вэ, Даяаршил 3.0, Алсын хараа-Эрхэм зорилго, үнэт зүйл, Бусдад эерэгээр нөлөөлөх аргууд” зэрэг агуулгын хүрээнд шинэ мэдлэг, мэдээлэл авсан. -Байгууллагын “Мэдээллийн цаг” арга хэмжээнд тогтмол хамрагдаж байна. Тухайлбал, Философийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Анарагийн “Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент" сэдэвт лекцийг сонсон, сорилд хамрагдсан. -Мөн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга" сэдвээр мэдээлэл авсан. -Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (шилэн хяналт) ашиглалтад орж байгаатай холбогдуулан тус порталын ашиглалт, хэрэглээний талаарх цахим сургалтад хамрагдсан. -Удирдлагын академи буюу | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан Төрийн чадамжийг бүрдүүлэх нь цахим, танхим хосолсон 24 цагийн хичээлийг судлан, шалгалт өгч 2024-02-07-ны өдөр №24/0210 дугаартай сертификатыг гардан авсан.<br>Хавсралт: 2 файл | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Зөрчлийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Энэбиш Бямбацэцэг /................................................./ Огноо: .........................